

МОНГОЛБАНКНЫ “САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ” АЯНЫ ИЛТГЭЛИЙН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Тэмцээний зорилго:

Оюутан, судлаачдын санхүүгийн боловсролын чиглэлээр судалгаа хийх чадварыг хөхүүлэн дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлж, олон нийтийн эдийн засгийн бодлогын талаарх ойлголтыг дээшлүүлэх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ:

1. Их дээд сургуулийн оюутнууд
2. Судлаачид

Гурав. Илтгэлийн сэдэв:

“Санхүүгийн боловсрол” аяны хүрээнд зохион байгуулж буй энэхүү илтгэлийн уралдаанд дараах сэдвүүдээс сонгож бичих боломжтой бөгөөд онол, арга зүйн үндэслэлтэй, шинэлэг, оновчтой санааг дэвшүүлсэн байх нь чухал юм.

Оюутнуудад зориулсан:

1. Өрхийн хуримтлал болон хэрэглээнд нөлөөлж буй хүчин зүйлс
2. Иргэдийн хадгаламжид нөлөөлж буй валютын ханш болон инфляцийн нөлөөлөл
3. Иргэдийн санхүүгийн боловсрол ба өр зээл, хадгаламж, хөрөнгө оруулалтын хамаарал
4. Санхүүгийн боловсрол ба мэдлэгийн ялгаа, онцлог

Судлаачдад зориулсан:

1. Санхүүгийн боловсрол ба эдийн засгийн хамаарал
2. Иргэдийн санхүүгийн боловсролын түвшинг хэмжих арга зүй
3. Санхүүгийн боловсролын индекс тооцох арга зүйн асуудал
4. Иргэдэд зориулсан санхүүгийн боловсролын агуулга, хүртээмжийн асуудал

Дөрөв. Илтгэлд тавигдах ерөнхий шаардлага

Нэгдүгээр шат: Илтгэлийн хураангуй

- Сэдвийн хүрээнд өөрийн тавих илтгэлийн хураангуйг бичих:
 - Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, илтгэлийн нэрийг бичих
- Илтгэлийн хураангуйд тавих шаардлага:
 - Үгийн тоо: 500 үгэнд багтаан Монгол хэлээр бичих;
 - Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
 - Бусдын оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах)

- Бичгийн стандарт:
 - Фонт: Times New Roman;
 - Үсгийн хэмжээ: 12;
 - Мөр хоорондын зай: 1.5;
 - Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм;
- Илтгэлийн хураангуйг дараах шалгуур үзүүлэлтүүдээр шалгаруулна:
 - Онол, аргазүйн үндэслэлтэй;
 - Шинэлэг, оновчтой санал, санаачлагыг дэвшүүлсэн;
 - Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан;
 - Статистикийн арга хэрэгслүүдийг ашигласан;
 - Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, үр дүнд хүрсэн байх;

Хоёрдугаар шат: Илтгэл

- Илтгэлийн PowerPoint эсвэл PDF файлыг хураангуйтай хамт ирүүлэх:
 - Илтгэл нь гарчиг, агуулга, оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх
 - Бусдын оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах)
- Илтгэх чадвар:
 - Үзэгчдэд санаагаа хүргэх чадвар (ойлгомжтой, цэгцтэй)
 - Хувцаслалт, биеийн хэл
 - Үгийн сонголт, ярианы чадвар
 - Илтгэлийн хугацаа: 10 минут
- Илтгэлийн агуулга:
 - Илтгэл сэдвийн хүрээнд байгаа эсэх
 - Илтгэлийн бүтэц зохион байгуулалт
 - Илтгэлийн шинэлэг санаа гаргасан байдал

Тав. Шалгаруулалт

• 1-р шат Зохион байгуулах комисс илтгэлийн хураангуйг info@mongolbank.mn хаягаар болон Монголбанкны бичиг хэрэгт хүлээн авч уншиж, ангилал тус бүрээс 5 илтгэлийг эцсийн шатны шалгаруулалтад оруулна. Нэгдүгээр шатанд тэнцсэн оролцогчдод утсаар мэдэгдэх болно.

• 2-р шат Эхний шатнаас шалгарсан илтгэлүүдийг 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 10.00 цагт Монголбанкны В байрны 5 давхрын хурлын зааланд хэлэлцүүлнэ.

Зургаа. Шагналын сан

Оюутны ангилал

1-р байр - Өргөмжлөл, 700 000 /Долоон зуун мянган төгрөг/

2-р байр - Өргөмжлөл, 500 000 /Таван зуун мянган төгрөг/

3-р байр - Өргөмжлөл, 300 000 /Гурван зуун мянган төгрөг/

Судлаачдын ангилал

1-р байр - Өргөмжлөл, 1500 000 /Нэг сая таван зуун мянган төгрөг/

2-р байр - Өргөмжлөл, 1200 000 /Нэг сая хоёр зуун мянган төгрөг/

3-р байр - Өргөмжлөл, 900 000 /Есөн зуун мянган төгрөг/

Долоо. Материал хүлээн авах хугацаа, хаяг:

Хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 15-ний 18.00 цаг хүртэл электрон хэлбэрээр info@mongolbank.mn хаягаар илгээх мөн хэвлэмэл хэлбэрээр 2 хувийг Монголбанкны бичиг хэрэгт өгөх.

Хаяг: Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Б” байр Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв МОНГОЛБАНК

Дэлгэрэнгүй мэдээллийг www.mongolbank.mn веб хуудаснаас болон (976) 11-310081 утсаар лавлана уу.

МОНГОЛБАНК

ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

2017 он